



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1137

Мандалговь

「Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2017 оны 01 дугаар сарын 04-ний өдрийн хурлын санал дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрлийг хавсралт ёсоор олгосугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Ахуйн шавьж мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт, үйлчилгээ MNS5161-3:2002, өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг "Сайн түшиг" ХХК-нд үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс /Ц.Эрдэнэсүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Эрүүл мэндийн газар /Ц.Энхсайхан/-д тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



020000305

Аймгийн Засаг даргын 2017 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн тоот захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН  
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Сайнтушиг" ХХК	"Сайн түшиг"	Ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ	АҮХ-16/10/1034	3 жил



020030105